

ХАРЬЦУУЛСАН ХҮСНЭГТ

№	Үзүүлэлтүүд	Хуучин стандарт	Шинэчилж буй стандарт
1	Стандартын нэр /Монголоор/	Хаяг. Хаягийн бичвэрт тавих шаардлага MNS 6775:2019	Хаяг. Хаягийн бичвэрт тавих шаардлага MNS 6775:2023
2	Стандартын нэр /Англиар/	The address. The requirements for the text of address	The address. The requirements for the text of address
3	Хэрэгцээ шаардлага	.	<p>Монгол Улсын аж ахуйн бүхий л салбарт харилцаа холбоо, мэдээллийн технологийн хэрэглээ өргөнөөр нэвтэрч улс орноо “Цахим Үндэстэн” болох зорилтын хүрээнд өнөөдөр мөрдөгдөж буй стандартыг хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд уялдуулах, мэдээлэл харилцаа холбооны салбарт тус стандартыг мөрдөж буй үйлчилгээний компаниудыг стандарт мөрдөх талаар үнэн зөв мэдээллээр хангах зэрэг шаардлага урган гарсан.</p> <p>Энэхүү стандарт нь хаягийн бичвэрийг боловсронгуй болгож хаягийн нэгдсэн санг үүсгэх анхан шатны элементүүдийг стандартчилж өгсөн болно.</p> <p>Цаашид хаягжилтын нэгдсэн бодлого хэрэгжиж улсын хэмжээнд хаягжилтын нэгдсэн сантай болсон тохиолдолд шинэчлэн тохируулах шаардлагатай.</p>
4	Норматив эшлэл	<p>a) MNS 5217, Монгол кирилл үсгийн латин хөрвүүлэг</p> <p>b) MNS 5283, Гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага;</p> <p>c) MNS 6776, Шуудангийн үйлчилгээнд тавих шаардлага;</p>	<p>a) MNS 5217, Монгол кирилл үсгийн латин хөрвүүлэг</p> <p>b) MNS 5283, Гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага;</p> <p>c) MNS 6776, Шуудангийн үйлчилгээнд тавих шаардлага;</p> <p>d) MNS 5641, Монгол Улсын засаг захиргаа, газар нутаг дэвсгэрийн нэгжийн багц стандарт;</p>

		<p>d) MNS 5641, Монгол Улсын засаг захиргаа, газар нутаг дэвсгэрийн нэгжийн багц стандарт;</p> <p>e) ISO 19160-4, Хаяг. 4-р хэсэг: Олон улсын шуудангийн хаягийн бүрдэл ба загвар; UPU S42, Олон улсын шуудангийн хаяг, бүрдэл ба загвар</p>	<p>e) ISO 19160-4, Хаяг. 4-р хэсэг: Олон улсын шуудангийн хаягийн бүрдэл ба загвар;</p> <p>f) UPU S42, Олон улсын шуудангийн хаяг, бүрдэл ба загвар</p> <p>болон Дэлхийн Шуудангийн Байгууллага (UPU)-ын веб хуудас болон дараах эх сурвалжаас эшлэн ашигласан болно. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. https://delo-press.ru/journals/documents/oformlenie-dokumentov/34985-pravila-napisaniya-adresov/ 2. https://www.upu.int/en/Postal-Solutions/Programmes-Services/Addressing-Solutions#addressing-s42-standard 3. https://www.iso.org/standard/64242.html
5	Нэр томьёо, тодорхойлолт	<p>3.1 иргэн, хуулийн этгээдийн харьяаллын хаяг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу тухайн иргэн, хуулийн этгээдийн харьяаллыг тодорхойлсон мэдээлэл;</p> <p>3.2 үл хөдлөх хөрөнгө ба иргэн, хуулийн этгээдийн байршил /оршин суугаа/-ын хаяг иргэн, хуулийн этгээдийн байнга болон түр хугацаагаар оршин суугаа ба үл хөдлөх хөрөнгийн байршил нь хот, суурины аль хаягийн бүс, гудамж, байшин барилга, тоотод байгааг, хөдөө нутагт бол ямар газар орчинд байгааг тодорхойлсон мэдээлэл;</p>	<p>3.2 иргэн, хуулийн этгээдийн харьяаллын хаяг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу тухайн иргэн, хуулийн этгээдийн харьяаллыг тодорхойлсон мэдээлэл бөгөөд Иргэний үнэмлэх, хуулийн этгээдийн болон үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээнд ашиглагдана ;</p> <p>3.3 үл хөдлөх хөрөнгө ба иргэн, хуулийн этгээдийн байршил /оршин суугаа/-ын хаяг иргэн, хуулийн этгээдийн байнга болон түр хугацаагаар оршин суугаа ба үл хөдлөх хөрөнгийн байршил нь хот, суурины аль хаягийн бүс, гудамж, байшин барилга, тоотод байгааг, хөдөө нутагт бол ямар газар орчинд байгааг тодорхойлсон мэдээлэл бөгөөд иргэний үнэмлэх, албан баримт бичгийн хэвлэмэл хуудас, зар мэдээ, сурталчилгаа, төрөл бүрийн илгээмжийн хүргэлт зэрэгт ашиглагдана.</p>

		<p>3.9 шуудангийн хаяг иргэн, хуулийн этгээдийн шуудангийн илгээмж дээр бичсэн байршлын хаяг болон шуудангийн нэгдсэн кодын нийлбэр цогц;</p> <p>3.6 хаягийн талбай хүлээн авагчийн болон илгээгчийн хаягийн мэдээлэл бичихэд зориулсан</p> <p>3.10 шуудангийн нэгдсэн кодын формат шуудангийн нэгдсэн код үүсгэх зарчим</p>	<p>3.4 шуудангийн хаяг иргэн, хуулийн этгээдийн шуудангийн илгээмж дээр бичсэн байршлын хаяг болон шуудангийн нэгдсэн кодын нийлбэр цогц бөгөөд шуудангийн илгээмжийн ялгалт, хүргэлтэд ашиглагдана;</p> <p>3.6 хаягийн талбай хүлээн авагчийн болон илгээгчийн хаягийн мэдээлэл бичихэд зориулсан хэсэг;</p> <p>3.10 шуудангийн нэгдсэн кодын формат шуудангийн нэгдсэн код үүсгэх зарчим</p>
6	5. Шуудангийн хаягийн бичвэр	<p>Шуудангийн хаягийг шуудангийн сүлжээгээр дамжих илгээмжийн нүүрэн хэсэг дэх хаягийн талбайд бичихээс гадна хаягийн зориулалтын шошго болон албан бичгийн хэвлэмэл хуудсан дээр бичнэ.</p> <p>Баримт бичгийн хэвлэмэл хуудасны бүрдэлд байгууллагын хаягийг шуудангийн нэгдсэн кодыг хамт бичиж хэвлүүлнэ.</p> <p>Хаягийг хэрхэн зөв бичсэнээс тухайн шуудангийн илгээмжийг хаягт эзэнд нь хүргэх хугацаа шууд хамаарах тул шуудангийн ажилтан хаягийн бичилтээс тухайн илгээмжийг хүлээн авах байршлыг ямар ч эргэлзээгүйгээр шууд ойлгож мэдэхээр бичнэ.</p> <p>Шуудангийн илгээмжийг автомат машинаар ялгахад хаягийн элемент бүр маш тод, тодорхой байх шаардлагатай тул шуудангийн хаягийн бичвэрт хамааралгүй засвар, аливаа нэмэлт цэг, зураас, тэмдэг хэрэглэх болон очих</p>	<p>Шуудангийн хаягийг шуудангийн сүлжээгээр дамжих илгээмжийн нүүрэн хэсэг дэх хаягийн талбайд бичихээс гадна хаягийн зориулалтын шошго болон албан бичгийн хэвлэмэл хуудсан дээр бичнэ.</p> <p>Баримт бичгийн хэвлэмэл хуудсанд байгууллагын хаягийг шуудангийн нэгдсэн кодын хамт бичиж хэвлүүлнэ.</p> <p>Хаягийн бичвэр нь шуудангийн ажилтанд тухайн илгээмжийг хүлээн авах байршлыг ямар ч эргэлзээгүйгээр шууд ойлгогдохоор бичигдсэн байна.</p> <p>Шуудангийн илгээмжийг ялгахад хаягийн элемент бүр маш тод, тодорхой байх шаардлагатай бөгөөд шуудангийн хаягийн бичвэрт хамааралгүй засвар, аливаа нэмэлт цэг, зураас, тэмдэг хэрэглэх болон очих газрын нэр зэргийг өөрийн дураар товчилж бичихгүй.</p>

		<p>газрын нэр зэргийг өөрийн дураар товчилж бичихийг хориглоно.</p> <p>5.3 Шуудангийн хаягийн бичвэрийн дараалал</p> <p>Хаягийн элементийг жижиг нэгжээс том нэгж рүү дараах дарааллаар бичнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хэрэв хуулийн этгээд бол байгууллагын бүтэн болон товчилсон нэр, - харин хувь хүн бол овог нэр; - Хаалганы дугаар, байшингийн дугаар, гудамжны нэр; - Хороолол, хотхоны нэр, сум, дүүргийн нэр; - Аймаг, нийслэлийн нэр; - Шуудангийн нэгдсэн код; - Улсын нэр; <p>Мөр тус бүрийг бие даасан мөрөнд бичнэ</p>	<p>5.3 Шуудангийн хаягийн бичвэрийн дараалал</p> <p>Хаягийн элементийг жижиг нэгжээс том нэгж рүү дараах дарааллаар бичнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хуулийн этгээд бол байгууллагын бүтэн болон товчилсон нэр, - хувь хүн бол овог нэр; - Хаалганы дугаар, байшингийн дугаар, гудамжны нэр; - Хороолол, хотхоны нэр, сум, дүүргийн нэр; - Аймаг, нийслэлийн нэр; - Шуудангийн нэгдсэн код; - Улсын нэр; <p>Мөр тус бүрийг бие даасан мөрөнд бичнэ.</p>
7	5.4 Шуудангийн хаягийн талбай	<p>5.4.2 Хаягийг бичихдээ шуудангийн дугтуйн зүүн дээд буланд гадна ирмэгээс 15 мм-ээс багагүй зайд илгээгчийн, баруун, зүүн болон доод талаас тус бүр 15 мм-ийн зайтай хүлээн авагчийн хаягийг бичнэ.</p> <p>Бичихдээ хүлээн авагчийн хаягийг тойруулан ямар нэгэн хүрээ татах буюу эсхүл тэмдэглэгээ хийхгүй.</p>	<p>5.4.2 Илгээгчийн хаягийг бичихдээ, шуудангийн дугтуйн зүүн дээд буланд гадна ирмэгээс 15 мм-ээс багагүй зайд бичнэ.</p> <p>Хүлээн авагчийн хаягийг зүүн болон доод талаас тус бүр 15 мм-ийн зайтай бичнэ.</p> <p>Бичихдээ хүлээн авагчийн хаягийг тойруулан ямар нэгэн хүрээ татах буюу эсхүл тэмдэглэгээ хийхгүй.</p>
8	5.5 Хаягийн бичвэрт тавих	<p>к) Гудамж, талбай нь эрх бүхий этгээдээр баталгаажуулсан нэртэй болж амжаагүй ба огт</p>	<p>к) Гудамж, талбай нь эрх бүхий этгээдээр баталгаажуулсан нэртэй болж амжаагүй ба огт нэргүй</p>

	нийтлэг шаардлага	<p>нэргүй байгаа нөхцөлд эрх бүхий этгээд түр хугацаагаар шифр-дугаарлалт оноон өгч, хаягийн бичвэрт ашиглаж болно;</p> <p>м) Шуудангийн хаягийг харандаа, бэх болон гаднын нөлөөгөөр амархан баларч, унших боломжгүй болох зүйлээр бичихийг хориглоно;</p> <p>н) Хаягийн бүтцэд хамаарах элементийн аль нэг нь дутуу, дараалал зөрүүтэй хаягласан илгээмжийг шуудангийн байгууллага хүлээн авахгүй.</p>	<p>байгаа нөхцөлд эрх бүхий этгээдийн түр хугацаагаар оноож өгсөн шифр-дугаарлалтыг хаягийн бичвэрт ашиглана;</p> <p>м) Шуудангийн хаягийг бэх болон гаднын нөлөөгөөр амархан балрахгүй зүйлээр бичнэ;</p> <p>н) Хаягийн бүтцэд хамаарах элементийн аль нэг нь дутуу, дараалал зөрүүтэй хаягласан илгээмжийг шуудангийн байгууллага нь илгээгчид шаардлагатай мэргэжлийн зөвлөгөө дэмжлэг үзүүлэн залруулж хүлээн авна.</p>
	7. Улс хоорондын шуудангийн хаягийн бичвэрийн загвар	<p>7.1 Улс хоорондын шуудангийн хаягийг бичих ерөнхий загварыг 3-р зурагт үзүүлэв. Улс хоорондын шуудангаар явуулах илгээмжид хүлээн авагчийн бүрэн хаягийн оронд товчлон томъёолсон үсэг, тоо болон ямар нэгэн тэмдэг хэрэглэхийг хориглоно.</p> <p>7.2 –оос 7.7 дуусталх жигээ загварууд</p>	<p>7.1 Улс хоорондын шуудангийн хаягийг бичих ерөнхий загварыг 3-р зурагт үзүүлэв. Улс хоорондын шуудангаар явуулах илгээмжид хүлээн авагчийн бүрэн хаягийн оронд товчлон томъёолсон үсэг, тоо болон ямар нэгэн тэмдэг хэрэглэхгүй.</p> <p>7.2 –оос 7.7 дуусталх жишээ загваруудыг Хавсралтаар оруулав.</p>
	8. Шуудангийн нэгдсэн код, түүнд тавих шаардлага	8.7 Шуудангийн нэгдсэн кодын талаарх мэдээллийг www.zipcode.mn цахим хаягаас дэлгэрэнгүй хэлбэрээр авч болно.	8.7 Шуудангийн нэгдсэн кодын талаарх мэдээллийг www.zipcode.mn цахим хаягаас эсхүл шуудангийн салбараас дэлгэрэнгүй хэлбэрээр авч болно.
10	Гүйцэтгэл	хэвийн	хэвийн
11	Зохиомж	хэвийн	сайжруулсан
12	Стандарт бичиглэл	хэвийн	сайжруулсан
13	Хуудасны тоо/үндсэн болон хавсралт/	16 хуудас (хавсралт 3 хуудас)-ны хамт	13 хуудас (хавсралт 4 хуудас)-ны (нүүр хуудас ороогүй)

14	Бусад		Агуулгын хувьд стандартын 20 хувийг шинэчлэн найруулсан.
----	-------	--	--